

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/**

### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

#### **1.1.Хуулийн зорилт**

1.Энэ хуулийн зорилт нь үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдал, нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж болзошгүй болон орчиндоо аюултай зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэх, байгалийн баялаг, төрийн нийтийн зориулалттай өмчийг ашиглахад эрх бүхий этгээдээс зөвшөөрөл олгох, олгосон зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, түүнчлэн зөвшөөрлийн ангилал, төрөл, тэдгээрийн бүртгэл, Монгол Улсын нутаг дэвсгэрт хориглох үйл ажиллагааг тогтоохтой холбоотой нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

#### **1.2.Зөвшөөрлийн хууль тогтоомж**

1.Зөвшөөрлийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### **1.3.Хуулийн үйлчлэх хүрээ**

1.Хүн, хуулийн этгээд хуулиар хориглосон, эсхүл зөвшөөрөл шаардахаас бусад төрлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн чөлөөтэй эрхэлж болох ба хуулиар зөвшөөрөл шаардах үйл ажиллагааг эрхлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн зориулалттай өмчийг ашиглахад зөвшөөрөл олгох, олгосон зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг тухайлсан хуулиар зохицуулаагүйгээс бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.

2.Монгол Улсад зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны жагсаалт, зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийг энэ хуулиар зохицуулна.

**3.Энэ хууль доор дурдсан харилцаанд үйлчлэхгүй:**

3.1.Монгол Улсын иргэнд газар өмчлөх эрх олгох;

3.2.гадаадын иргэн, харьяалалгүй хүнд цагаачлан оршин суух зөвшөөрөл олгох, гадаадын иргэнд Монгол Улсын хилээр нэвтрэх эрх олгох буюу Монгол Улсын виз олгох, Монгол Улсад хувийн хэргээр оршин суух зөвшөөрлийг олгох, олгосон виз, визийн зөвшөөрөл, зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

3.3.хурал, цуглаан, жагсаал, нийтийг хамарсан бусад арга хэмжээ зохион байгуулах;

3.4.Патентын тухай хуулийн 3.1.5-д заасан харилцаа;

3.5.Монгол Улсад гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар байгуулах;

3.6.сүм, хийд буюу шашны байгууллага байгуулах;

3.7.холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн байгууллага, төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдээс бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэх гэрээ байгуулах эрх олгох.

4.Хүн, хуулийн этгээд сайн дурын үндсэн дээр төрийн байгууллага, албан тушаалтан, бусад эрх бүхий этгээдээс дүгнэлт, батламж, тодорхойлолт гаргуулах харилцаанд энэ хууль хамаарахгүй.

5.Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд энэ хуульд заасан зөвшөөрөлөөр эрхлэх үйл ажиллагааг эрхлэхээс бусад төрийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбостойгоор төрийн байгууллага хооронд зөвшөөрөл авах, олгох харилцаанд энэхүү хууль хамаарахгүй.

#### **1.4.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**

**1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:**

1.1."зөвшөөрөл" гэж зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдээс хуульд заасан хугацаа, нөхцөл, шаардлагын дагуу тодорхой үйл ажиллагааг эрхлүүлэх, эсхүл байгалийн баялаг, төрийн нийтийн зориулалттай өмчийг ашиглуулахаар олгосон эрхийг;

1.2."зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд /цаашид "эрх бүхий этгээд" гэх/" гэж хуулиар зөвшөөрөл олгох бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан төрийн байгууллага, албан тушаалтан, эсхүл чиг үүрэг, бүрэн эрхийг шилжүүлэн авсан этгээдийг;

**1.3.“зөвшөөрөл эзэмшигч” гэж тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэхээр эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авсан этгээдийг.**

**1.5.Зөвшөөрөл олгох, сунгах, шинээр бий болгоход  
баримтлах зарчим, хэрэгжүүлэх хүрээ**

1.Эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох, сунгах болон холбогдох бусад харилцаанд доор дурдсан зарчмыг баримтална:

1.1.үндэсний аюулгүй байдал, нийтийн эрх ашиг, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах;

1.2.хууль дээдлэх;

1.3.ил тод, шуурхай байх;

1.4.бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлэх;

1.5.хуульд зааснаас бусад баримт бичиг, төлбөр, хураамж шаардахгүй байх;

1.6.хуульд заасан тохиолдолд зөвшөөрөл олгох.

2.Зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг эрхлэх эрх хуульд заасны дагуу тухайн зөвшөөрлийг авсан өдрөөс үүснэ.

3.Хуульд зааснаас бусад тохиолдолд Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд дагуу шилжүүлэн авсан этгээд аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, лиценз, бүртгэл явуулахыг хориглоно.

4.Төрийн байгууллага, албан тушаалтан хуульд зааснаас бусад тохиолдолд зөвшөөрлийг шинээр бий болгосон, олгосон бол хуульд заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болох бөгөөд үүсэх үр дагаврыг зөвшөөрлийг шинээр бий болгосон, олгосон этгээд хариуцна.

5.Засгийн газар үндэсний аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, нийтийн ашиг сонирхол, үр ашигтай өрсөлдөөний нөхцөлийг бүрдүүлэх үүднээс Засгийн газар, түүний харьяа байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээдээс олгодог зөвшөөрлийг олгох, сунгах үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар хязгаарлалт хийж болно.

6.Хуульд заасан тохиолдолд эрх бүхий байгууллагын тогтоосон хувь, хэмжээнд багтаан эрх бүхий этгээд зөвшөөрлийг олгоно.

7.Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд хуульд заасны дагуу зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэхээр заасан үйл ажиллагааг зөвшөөрлийг авсны дараа эрхэлнэ.

8.Хуульд өөрөөр заагаагүй бол нэг зөвшөөрлийг зөвхөн нэг хүн, эсхүл нэг хуулийн этгээдийн нэр дээр олгоно.

9.Хуульд заасан тохиолдолд тухайн зөвшөөрлийг зөвхөн хуулийн этгээдэд, тэр дундаа хуулийн этгээдийн тодорхой төрөл, хэлбэрээр байгуулагдсан хуулийн этгээдэд, эсхүл хувь хүнд, тэр дундаа Монгол Улсын иргэнд олгоно.

10.Хуульд заасан тохиолдолд зарим төрлийн зөвшөөрлийг зөвхөн холбогдох бусад зөвшөөрлийг эзэмшигч этгээдэд олгоно.

11.Хуульд заасан тохиолдолд зөвшөөрлийг олгох, сунгах ажиллагааг хөнгөвчилсөн/хялбаршуулсан горимоор явуулж болно.

12.Эрх бүхий этгээд уялдаа холбоо бүхий зарим төрлийн зөвшөөрлийг зөвшөөрөл олгох, сунгах үйл ажиллагааг нэг цэгийн үйлчилгээний хэлбэрээр зохион байгуулж болно.

13.Хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрлийг олгох, сунгах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж болно.

14.Хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрлийг олгосон хугацаанд зөвшөөрөл эзэмшигч хувь хүн бол овог, эцгийн нэр, нэрээ өөрчлөх, хуулийн этгээд бол өөрийн оноосон нэрийг өөрчлөхийг хориглоно.

15.Хуульд заасан тохиолдолд зөвшөөрөл эзэмшигчид тусгай зөвшөөрөлд зааснаас өөр үйл ажиллагаа, эсхүл давхар ажил эрхлэхгүй байх болон хуульд заасан бусад хязгаарлалтыг тавьж болно.

16.Хуульд заасан тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг тодотгосон үг, тэмдэглэгээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрэглэх бөгөөд тухайн үг, тэмдэглэгээг тухайн үйл ажиллагаа эрхэлж байгаа, эсхүл үг үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан гэсэн сэтгэгдэл төрүүлэхүйц байдлаар бусад этгээд ашиглах, хэрэглэхийг хориглоно.

17.Зөвшөөрлийг шинээр бий болгоход тухайн үйл ажиллагааг төрөөс зохицуулах шаардлагатай эсэх, зөвшөөрөл нь зохицуулалтын зохистой арга хэрэгсэл мөн эсэх, зөвшөөрөл нь нийгэм, эдийн засгийн хувьд үр ашигтай байх эсэхэд судалгаа, үнэлгээ хийх зарчмыг баримтлан олон улсын жишиг, стандартыг харгалзана.

18.Энэ зүйлийн 17 дахь хэсэгт заасан судалгаа, үнэлгээ хийх ажиллагааг Засгийн газар баталсан аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ ЗӨВШӨӨРӨЛ

### **2.1 дүгээр зүйл. Зөвшөөрлийн ангилал**

1. Зөвшөөрлийг түүний зорилго, олгох нөхцөл, үйл ажиллагааны эрсдэлийн түвшингөөс хамааруулан доор дурдснаар ангилна:

- 1.1.тусгай зөвшөөрөл;
- 1.2.энгийн зөвшөөрөл.

2. Тухайн зөвшөөрлийн зориулалтаас хамаарч зөвшөөрөл нь нэг удаагийн болон олон удаагийн шинжтэй байж болно.

3. Тусгай зөвшөөрлийг хуульд заасан тохиолдолд тодорхой тусгай зөвшөөрөлд тавигдах нөхцөл, шаардлагыг бүрэн хангуулах үүднээс урьдчилсан байдлаар олгож болно.

4. Тусгай зөвшөөрөл, түүнийг баталгаажуулсан зөвшөөрлийн баримт бичгийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлэхийг хориглоно.

### **2.2. Зөвшөөрлийн код**

1. Зөвшөөрлийн нэгдсэн бүртгэл хөтлөх, статистик мэдээг эрхлэн гаргах, лавлагаа өгөх, цахим хэлбэрээр зөвшөөрөл олгох зорилгоор зөвшөөрлийг кодлоно.

2. Энэ хуульд заасан Зөвлөл зөвшөөрлийн кодыг эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, барааны ангилалын жагсаалт болон үндэсний кодыг харгалзан тогтооно.

### **2.3. Зөвшөөрлийн агуулга**

1. Зөвшөөрөлд доор дурдсан зүйлийг тусгана:

- 1.1. зөвшөөрлийг олгосон байгууллагын нэр;
- 1.2. зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг;
- 1.3. эрхлэх үйл ажиллагааны төрөл;
- 1.4. зөвшөөрлийн хугацаа;
- 1.5. зөвшөөрлөөр эрхлэх үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага;
- 1.6. зөвшөөрлийн дугаар, олгосон он, сар, өдөр;
- 1.7. зөвшөөрөл олгосон байгууллагын эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга /тэмдэг/.

2.Хуульд тусгайлан заасан тохиолдолд энэ зүйлийн 1-д зааснаас бусад мэдээллийг зөвшөөрөлд тусгаж болно.

#### **2.4.Зөвшөөрлийн хугацаа**

1.Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг 5 жилээс доошгүй, энгийн зөвшөөрлийг 3 жилээс доошгүй хугацаагаар олгоно.

2.Зөвшөөрлийг хуульд заасан тохиолдолд хугацаагүй олгож болно.

3.Зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол анх олгосон хугацаанаас нь доошгүй хугацаагаар сунгана.

#### **2.5.Зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулах**

1.Хуульд заасан тохиолдолд эрх бүхий этгээд зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулна.

2.Гэрээний нөхцөл, шаардлага, гэрээ байгуулахтай холбоотой харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД, ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ**

#### **3.1 дүгээр зүйл.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд**

1.Энэ хуулийн Долоодугаар бүлэгт заасан этгээд зөвшөөрлийг олгох бөгөөд хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд зөвшөөрөл олгох бүрэн эрхээ бусад этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

#### **3.2 дугаар зүйл.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн бүрэн эрх**

1.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1.1.хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

1.2.тухайн зөвшөөрлийн нөхцөл, шаардлагатай холбогдох мэдээ, тайланг зөвшөөрөл эзэмшигчээс авах;

1.3.зөвшөөрлийг хугацааг хуульд заассан журмын дагуу сунгах;

1.4.хуульд заасан тохиолдол бий болсон бол зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох;

1.5. зөвшөөрөл олгохтой холбоотой зааварчилгаа, зөвлөмж гаргах, хуульд заасан бол зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох талаар нарийвчилсан журам батлах.

2. Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд дараахь үүрэг хүлээнэ:

2.1. энэ хууль болон бусад хуульд заасан зарчмыг баримтлах;

2.2. зөвшөөрөл хүсэгч, зөвшөөрөл эзэмшигчид зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа эрхлэх, зах зээл чөлөөтэй өрсөлдөхөд ялгамжтай хандахгүй байх, түүнчлэн өрсөлдөөнийг хязгаарлах зорилгоор хуульд зааснаас бусад үндэслэлээр зөвшөөрлийг олгохоос татгалзах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох арга хэмжээг авахгүй байх;

2.3. хуулиар тогтоосон бүрэн эрх, журмын хүрээнд зөвшөөрөл олгох;

2.4. зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэр болон холбогдох бусад мэдээллийг зөвшөөрлийн цахим нэгдсэн санд оруулах, нийтэд хүртээмжтэй хэлбэрээр мэдээлэх;

2.5. зөвшөөрөл олгох, олгосон зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эсэх тухай шийдвэрийг хуульд заасан хугацаанд гаргах, зөвшөөрлийн цахим нэгдсэн санд тухайн шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор бүртгүүлэх;

2.6. зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл хулээн авах, түүнийг магадлан шийдвэр гаргах, зөвшөөрлийг олгох, олгосон зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үйл ажиллагааны мэдээллийг нээлттэй, ил тод байлгах;

2.7. зөвшөөрөл эзэмшигч, зөвшөөрөл хүсэгч нарт зөвлөгөө, туслалцаа үзүүлэх.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ОЛГОСОН ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ**

### **4.1. Зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргах**

1. Хуульд өөрөөр заагаагүй бол нэг удаагийн шинжтэй энгийн зөвшөөрлөөс бусад зөвшөөрөл хүсэгч нь эрхлэх үйл ажиллагааны төрөл, хугацааг тодорхой дурдсан зөвшөөрөл хүссэн өргөдлөө холбогдох баримт бичгийн хамт эрх бүхий этгээдэд гаргах ба эрх бүхий этгээд өргөдөл хулээн авахаас татгалзах эрхгүй.

2. Зөвшөөрөл хүссэн өргөдөл нь иргэн, хуулийн этгээдээс төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гаргах нийтлэг шаардлагыг хангасан байна.

3. Зөвшөөрөл хүсэгч дараахь баримт бичгийг бүрдүүлж өргөдөлд хавсаргана:

3.1.зөвшөөрлийн нэр төрөл, түүнд холбогдох үйл ажиллагаа эрхлэх, төрийн нийтийн зориулалттай өмчтэй холбогдох эрхийг эзэмших, ашиглах зорилго, үндэслэлийг тодорхойлон тайлбарласан баримт бичиг;

3.2.зөвшөөрөлд авахад тавих хуульд заасан нийтлэг нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичиг;

3.3.зөвшөөрөл хүсэгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, зөвшөөрөл хүсэгч нь хувь хүн бол иргэний үнэмлэхний хуулбар, түүнтэй адилтгах бусад баримт бичиг;

3.4.хуульд заасан бол улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

3.5.хуульд заасан бол зөвшөөрөл хүсэгчид тавигдах тусгайлсан нөхцөл, шаардлага хангасныг нотолсон бусад баримт бичиг.

4.Энэ зүйлийн 3.3 дахь заалтад хувь хүний зөвшөөрөл авахад шаардагдах бичиг баримтыг эрх бүхий этгээд биечлэн хүлээн авсан тохиолдолд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ.

5.Эрх бүхий этгээд нь хуульд зааснаас бусад нөхцөл, шаардлага, баримт бичиг, төлбөр, хураамж, нэмэлт нөхцөл, шаардлага тавихыг хориглоно.

6.Зөвшөөрөл хүссэн өргөдөл бүрдэл хангаагүй бол өргөдөл хүлээн авсан этгээд энэ тухай өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор зөвшөөрөл хүссэн этгээдэд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

7.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу цахимаар мэдэгдсэн тохиолдолд тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд мэдээлэл илгээсэн болон хүлээн авах цахим хаяг, илгээсэн огноо, цаг, минут, товч агуулга, албан тушаалтны нэр болон шаардлагатай бусад мэдээллийг тусгана.

8.Өргөдөл хүлээн авсан этгээд нь өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг хүлээн авсан болохыг нотолсон баримтыг олгох ба тухайн баримтад өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг хүлээн авсан болон хариу өгөх хугацааг тусгасан байна.

9.Тодорхой нэг удаагийн тохиолдолд энгийн зөвшөөрлийг хүссэн өргөдлийг амаар биечлэн гаргаж болох бөгөөд өргөдлийг хүлээн авч байгаа этгээд тэмдэглэн авч, өргөдөл гаргагчийн гарын үсгийг зуруулна. Гарын үсгээ зурж чадахгүй бол энэ тухай тэмдэглэнэ.

10.Энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан тохиолдолд энэ зүйлийн 3 дахь хэсэг хамаарахгүй.

## **4.2 дугаар зүйл.Өргөдлийг шийдвэрлэх журам**

1.Энэ хуулийн 4.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсэгт заасан өргөдөл тухай бүр зөвшөөрөл олгох эсэх асуудлыг амаар хариу өгч болох бөгөөд шаардлагатай бол магадлан шалгаж бичгээр хариу өгч болно. Амаар хариуг өгсөн тохиолдолд тэмдэглэлд хэрхэн шийдвэрлэсэн талаар тодорхой тусгана.

2.Бичгээр гаргасан энгийн зөвшөөрөл хүссэн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магдлан шалгаж, тэдгээрийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.Эрх бүхий этгээд тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор магадлан шалгаж, санал дүгнэлт гаргана.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан магадлан шалгах, санал дүгнэлт гаргах ажиллагааг холбогдох байгууллага, албан тушаалтан, шинжээчийг оролцуулах байдлаар хийж болно.

5.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан магадлан шалгаж, санал дүгнэлт гаргах хугацааг баримт бичгийн цар хүрээ, хэмжээг харгалзан ажлын 5 өдрөөр сунгаж болно.

6.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрлийн өргөдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэх шийдвэрийг гаргах бөгөөд тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг эрх бүхий бусад байгууллагын санал дүгнэлт, зөвшөөрөл, зөвшилцсөний үндсэн дээр гаргахаар хуульд заасан бол ажлын 10 хоногоор сунгаж болно.

7.Энэ зүйлийн 3, 5 дахь хэсэгт заасан магадлан шалгах хугацаа нь энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан хугацаанд багтах бөгөөд магадлан шалгах, санал дүгнэлт гаргах аргачилсан заавар, маягтыг Засгийн газар батална.

8.Зөвшөөрөл хүссэн өргөдөл хүлээн авах, хянан шийдвэрлэх, зөвшөөрөл олгох үйл явцтай танилцах, магадлан шалгах, зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбогдуулан гарсан санал, хүсэлт, гомдлын шийдвэрлэлтийн явц болон шийдвэрлэлтийн талаар зөвшөөрөл хүсэгчийн мэдээлэл авах боломжийг хангасан цахим арга, хэлбэрийг ашиглаж болно.

## **4.3.Зөвшөөрөл олгох тухай шийдвэр гаргах**

1.Зөвшөөрлийн жагсаалтад нэр заасан эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг зөвшөөрөл хүсэгч тус бүрээр дангаар, эсхүл хамтран гаргана.

2.Хуулиар зөвшөөрсний дагуу энэ хуулийн Долоодугаар бүлэгт заасан эрх бүхий этгээд зөвшөөрөл олгох болон түүнтэй холбогдох бусад чиг үүрэг, бүрэн эрхийг холбогдох этгээд шилжүүлсэн тохиолдолд энэ зүйлийн 1 хэсэг хамаарахгүй.

2.Хуульд өөрөөр заагаагүй бол тусгай зөвшөөрлийг олгох шийдвэрийг тухайн байгууллагын удирдлага гаргана.

3.Зөвшөөрөл нь олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

#### **4.4 дүгээр зүйл.Зөвшөөрөл хүссэн өргөдөлд хариу мэдэгдэх**

1.Эрх бүхий этгээд энэ хуулийн 4.2 дугаар зүйлийн 2, 6 дахь хэсэгт заасан зөвшөөрөл олгосон, эсхүл татгалзсан тухай шийдвэр гаргаснаас хойш ажлын таван өдрийн дотор хүсэлт гаргасан этгээдэд хариу мэдэгдэнэ.

2.Зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрт үнэслэлийг тодорхой заана.

3.Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд тухайн этгээдээс 6 сарын дотор дахин татгалзсан шийдвэрт заагдсан тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээж авахгүй.

4.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд хариу өгөөгүй нь холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэл болно.

#### **4.5 дугаар зүйл.Зөвшөөрлийн баримт бичиг**

1.Эрх бүхий этгээд нь зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтээр, эсхүл хуульд заасан тохиолдолд зөвшөөрөл олгосныг баталгаажуулан зөвшөөрлийн баримт бичиг буюу гэрчилгээ, түүнтэй адилтгах эрхийн бичиг, бусад үнэт цаас бүхий баримт бичиг олгож болно.

2.Зөвшөөрлийн баримт бичиг нь зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаанд зөвшөөрөл олгосон шийдвэр, зөвшөөрлийн лавлагааны нэгэн адил эрх зүйн хүчинтэй байна.

3.Зөвшөөрлийн баримт бичгийг үрэгдүүлэх, гэмтээх, алдах, хүлээж аваагүй байх нь зөвшөөрлийг хүчингүй гэж үзэх үндэслэл болохгүй.

#### **4.6 дугаар зүйл.Зөвшөөрлийг сунгах**

1.Хугацаатай олгосон зөвшөөрлийг сунгах тухай өргөдлийг хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө гаргана.

2.Зөвшөөрөл эзэмшигч нь тухайн зөвшөөрлийн хугацааг сунгах тухай өргөдөл гаргасан ба уг этгээд нь холбогдох хууль тогтоомж зөрчөөгүй, хуульд

заасан нөхцөл, шаардлага хангаж байгаа бол зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд тухайн зөвшөөрлийн хугацааг сунгана.

3.Зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол анх олгосон хугацаанаас нь доошгүй хугацаагаар сунгана. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангаж байгаа зөвшөөрөл эзэмшигч нь татварын өр төлбөргүй, байнгын тогтвортой ажлын байр бий болгосон бол зөвшөөрлийн хугацааг анх олгосон хугацааг хоёр дахин нэмэгдүүлж сунгаж болно.

4.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд зөвшөөрлийг сунгах асуудлыг өргөдөл, хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангаж байгаа талаарх баримтыг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд хэрэв энэ хугацаанд хариу өгөөгүй бол зөвшөөрөл сунгагдсанд тооцно.

5.Зөвшөөрөл эзэмшигч нь хуульд заасан зохих нөхцөл, шаардлагыг хангахгүй байгаа тохиолдолд зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзаж болох бөгөөд энэ тохиолдолд үндэслэл бүхий хариуг энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.

#### **4.7 дугаар зүйл.Сонгон шалгаруулалт**

1.Эрх бүхий этгээд хуульд заасан бол сонгон шалгаруулалтын журмаар зөвшөөрлийг ологоно.

2.Сонгон шалгаруулалтын журмаар зөвшөөрлийг олгох харилцааг тухайлсан хуулиар нарийвчлан зохицуулна.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ**

#### **5.1 дугээр зүйл.Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх**

1.Эрх бүхий этгээд дараахь тохиолдолд зөвшөөрлийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

1.1.зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;

1.2.хуульд заасан мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл буруу гаргасан.

2.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл байгаа тухай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан мэдэгдэж, мэдэгдлийг хүргүүлсэн огноог тэмдэглэлд тусгана.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш зөвшөөрөл эзэмшигч ажлын 10 өдрийн дотор зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа эрх бүхий этгээдэд ирүүлээгүй бол зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

4.Эрх бүхий этгээд нь зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай шийдвэрийн талаар зөвшөөрөл эзэмшигч болон харьялах татварын албанад ажлын 2 өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.

5.Эрх бүхий этгээд нь зөвшөөрлийг түдгэлзүүлсэн үндэслэл, нөхцөл арилсан тохиолдолд уул зөвшөөрлийг сэргээнэ.

## 5.2 дугаар зүйл.Зөвшөөрлийг хүчингүй болгох

1.Зөвшөөрлийг дараахь тохиолдолд хүчингүй болгоно:

1.1.зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

1.2.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, тусгай зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй;

1.3.зөвшөөрөл эзэмшигч нийтийн эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчин, үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлсэн, их хэмжээний хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон;

1.4.зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа зөрчсөн;

1.5.зөвшөөрөл, түүнийг баталгаажуулсан баримт бичгийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад шилжүүлсэн, худалдсан, бэлэглэсэн, барьцаалсан;

1.6.тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг нэг жилийн хугацаанд явуулаагүй;

1.7.тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

1.8.зөвшөөрөл эзэмшигч нь хүн бол иргэний эрх зүйн чадамжгүйд тооцогдсон, хуулийн этгээд бол дампуурсан, эсхүл татан буугдсан;

1.9.хуульд заасан бусад.

Тайлбар: Энэ хуулийн 5.2 дугаар зүйлийн 1.4 дэх заалтад заасан "удаа дараа" гэж 2 буюу түүнээс дээш зөрчсөнийг ойлгоно.

## 5.3 дугаар зүйл.Зөвшөөрлийг хүчингүй болгох журам

1.Эрх бүхий этгээд зөвшөөрлийг хүчингүй болгох үндэслэл байгааг мэдсэн даруйд зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэнэ.

2.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 1 дахь хэсэгт заасан үндэслэл байгаа тухай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан мэдэгдэж, мэдэгдлийг хүргүүлсэн огноог тэмдэглэлд тусгана.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш зөвшөөрөл эзэмшигч 30 хоногийн дотор зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбар, холбогдох баримтыг эрх бүхий этгээдэд ирүүлээгүй бол зөвшөөрлийг хүчингүй болгоно.

4.Зөвшөөрөл эзэмшигч энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд тайлбар өгөөгүй, мэдэгдэлд заасан үндэслэлд гомдол гаргаагүй бол зөвшөөрөл хүчингүй болгох үндэслэлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

5.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаа дууссанаас хойш 14 хоногийн дотор зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг шийдвэрлэнэ.

6.Эрх бүхий этгээд нь зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийн талаар зөвшөөрөл эзэмшигч болон харьялах татварын албанд 3 хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ.

#### **5.4 дүгээр зүйл.Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосоны үр дагавар**

1.Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд уг зөвшөөрлийн дагуу явуулах үйл ажиллагаа түдгэлзэх, мөн бусадтай байгуулсан холбогдох гэрээний үйлчлэлийг түр зогсоож болно.

2.Зөвшөөрлийг хүчингүй болгосон нь тухайн зөвшөөрөл эзэмшигч этгээдээс зөвшөөрлийн дагуу эрхлэх үйл ажиллагаатай холбогдуулан бусадтай байгуулсан гэрээг цуцлах үндэслэл болно.

3.Зөвшөөрлийг хүчингүй болгосны улмаас бусдад учруулсан хохирлыг зөвшөөрөл эзэмшиж байсан этгээд нөхөн төлнө.

4.Зөвшөөрлийг хууль бусаар олгосны улмаас бусдад учирсан хохирлыг тухайн зөвшөөрөл олгох шийдвэр гаргасан эрх бүхий этгээд болон тухайн асуудал хариуцсан албан тушаалтан, эрх шилжүүлэн авсан этгээд нөхөн төлнө.

5.Төрийн албан тушаалтан зөвшөөрөл олгох журмыг зөрчсөн, эсхүл үүрэгт ажилдаа илтэд болгоомжгүй хандсан, эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүй, үүсч болох хохирлоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүйгээс бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг арилгана.

6. Эрх бүхий этгээд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд тухайн этгээдээс 6 сарын дотор дахин хүчингүй болсон шийдвэрт заагдсан тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээж авахгүй.

### 5.3 дугаар зүйл. Зөвшөөрөл дуусгавар болох

1. Дараахь үндэслэлээр зөвшөөрөл дуусгавар болох бөгөөд эрх бүхий этгээд зөвшөөрөл дуусгавар болсон бол зөвшөөрлийн цахим санд холбогдох хөдөлгөөнийг хийнэ:

1.1. Зөвшөөрөл эзэмшигч нь хүн бол нас барсан болон түүнийг нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон хуулийн этгээд бол татан буугдсан;

1.2. зөвшөөрлийн хугацаа дууссан;

1.3. зөвшөөрлийг хүчин төгөлдөр бус гэж тооцсон;

1.4. эрх бүхий этгээд зөвшөөрлийг хүчингүй болгосон.

2. Зөвшөөрөл эзэмшигчийн тодорхой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусгавар болсон нь уг тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагаатай холбогдол бүхий бусад үйл ажиллагаанд олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл мөн дуусгавар болно.

**ЗУРГАДУГААР БҮЛЭГ  
ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ,  
ЗӨВШӨӨРЛИЙН БҮРТГЭЛ, МЭДЭЭЛЭЛ**

### 6.1 дүгээр зүйл. Зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

1. Зөвшөөрөл эзэмшигч нь дараахь эрхийг эдэлнэ:

1.1. зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг эрхлэх;

1.2. зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргах, зөвшөөрлийг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой мэдээлэл, лавлагааг авах;

1.3. хуульд заасны дагуу зөвшөөрлийг бусдад шилжүүлэх;

1.4. зөвшөөрлийн цахим мэдээллийн сан оруулсан тухайн зөвшөөрөлтэй холбоотой мэдээлэл бүрэн бус, алдаатай, буруу бол запруулах талаар эрх бүхий этгээдэд хүсэлт гаргах;

1.5. хуульд бусад.

2. Зөвшөөрөл эзэмшигч нь дараахь үүрэг хүлээнэ:

2.1. хуульд заасан баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх;

2.2. тухайн үйл ажиллагааг эрхлэх хуулиар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаж ажиллах;

2.3.хуулиар хориглосон, эсхүл хязгаарласан тохиолдолд зөвшөөрөлд зааснаас өөр бусад үйл ажиллагаа эрхлэхгүй байх;

2.4.хуульд өөрөөр заагаагүй бол зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг байнга эрхлэх явуулах;

2.5.зөвшөөрлийг эрх бүхий этгээдээс авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор энэ тухай татварын албанад мэдэгдэж, татвар төлөгчийн гэрчилгээнд тэмдэглүүлэх;

2.6.санхүүгийн үйлчилгээний зөвшөөрөл эзэмшигч мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаархи хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

2.7.үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын болон үндэсний стандартыг дагаж мөрдөх;

2.8.зөвшөөрлийн хүрээнд хэрэглэгчийг ялгаварлахгүйгээр үйлчилгээгээр шуурхай хангах;

2.9.хуульд заасан бусад.

## 6.2.Зөвшөөрлийн цахим нэгдсэн сан

1.Зөвшөөрэлтэйгээр энэ хуульд заасан үйл ажиллагаа эрхлэхэд олгосон бүх зөвшөөрлийн бүртгэл, зөвшөөрөлтэй холбоотой нийтлэг мэдээллийг агуулсан зөвшөөрлийн цахим нэгдсэн сантай байх ба уг санг энэ хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан Зөвлөлийн ажлын алба эрхэлнэ.

2.Эрх бүхий этгээд нь зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай шийдвэр, дуусгавар болсон, зөвшөөрлийг барьцаалсан, шилжүүлсэн тухай мэдээллийг хуульд заасан журмын дагуу зөвшөөрлийн цахим нэгдсэн сан /цаашид "Зөвшөөрлийн сан" гэх-/д бүртгүүлнэ.

3.Эрх бүхий этгээдээс ирүүлсэн энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэр, мэдээлэлийг Зөвлөлийн ажлын алба ажлын гурав өдрийн дотор бүртгэж, зөвшөөрлийн цахим нэгдсэн санд байршуулах, нийтэд мэдээлэх арга хэмжээг авна.

4.Зөвшөөрлийн цахим нэгдсэн сангийн мэдээлэл, түүнийг бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбогдсон журмыг Засгийн газар батална.

5.Энэ хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан Зөвлөлийн ажлын алба зөвшөөрлийн бүртгэлийг цахим хэлбэрт оруулж, мэдээллийн сан үүсгэх,

түгээх, ашиглах, түүний байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах үүрэгтэй.

### **6.3 дугаар зүйл.Зөвшөөрлийн лавлагаа, мэдээлэл**

1.Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, дуусгавар болгохтой холбоотой хүсэлт гаргасан этгээд, түүний бүрдүүлсэн баримт бичиг болон зөвшөөрөл олгох, бүртгэх, хяналт тавих эрх бүхий этгээдийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл нээлттэй, ил тод байна.

2.Тусгай ба энгийн зөвшөөрөлтэй холбоотой энэ хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан мэдээлэлтэй холбогдсон лавлагааг сонирхогч этгээдийн хүсэлтээр олгоно.

3.Зөвшөөрөл эзэмшигчтэй холбоотой мэдээлэл хуульд заасны дагуу тухайн этгээдийн нууцад хамаарахаар бол түүнтэй холбоотой лавлагааг зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлийн үндсэн дээр олгоно.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан лавлагааг ажлын таван өдрийн дотор, бусад лавлагааг ажлын гурван өдрийн дотор олгоно.

## **ДОЛООДУГААР БҮЛЭГ ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА, ЗӨВШӨӨРЛӨӨР ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

### **7.1 дүгээр зүйл.Хориглох үйл ажиллагаа**

1.Монгол Улсын нутаг дэвсгэрт дараах төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

1.1.хар тамхи, хуульд өөрөөр заагаагүй бол мансууруулах үйлчилгээтэй ургамал тариалах;

1.2.хар тамхи, хуульд өөрөөр заагаагүй бол мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн угтвар бодисыг агуулсан эм, бэлдмэлийг үйлдвэрлэх, улсын хилээр нэвтрүүлэх, худалдах, үйлчлэх;

1.3.садар самуун явдлыг зохион байгуулах, түүнийг аливаа хэлбэрээр сурталчлах, дэмжих;

1.4.хуульд өөрөөр заагаагүй бол казиногийн үйл ажиллагаа эрхлэх;

1.5.олон шатлалт маркетинг буюу пирамид тогтолцооны замаар ашиг хонжоо олох үйл ажиллагаа;

1.6.аюултай хог хаягдлыг ашиглах, хадгалах, түр байршуулах, устгах зорилгоор Монгол Улсад импортоор оруулах;

- 1.7.аюултай хог хаягдлыг Монгол Улсын хил дамжуулан тээвэрлэх;
- 1.8.үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх;
- 1.9.төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа эрхлэх.

Тайлбар:энэ зүйлийн 1.4 дэх заалтад заасан “казиногийн үйл ажиллагаа эрхлэх”-ийг хориглох гэдэгт мөнгө буюу түүнийг орлогч металл /токенс/ хэрэглэн тоглодог электрон хэрэгсэл, слот машин, мөн тоглоомын үйл ажиллагаанд мөнгийг орлуулан хэрэглэх зориулалтын тусгай хуванцар зоос /чип/ буюу шоо, хөзөр, тэдгээрт зориулсан тоглоомын тусгай ширээ зэрэг казиногийн зориулалтаар өрөө, тасалгаа, тоног, төхөөрөмжийг ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршсан тоглоом тоглуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэж ойлгоно.

### **7.2 дугаар зүйл.Тусгай зөвшөөрлийн жагсаалт**

1.Байгаль орчны чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх бөгөөд дараахь этгээд олгоно:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
1.1.тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах	Тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.2.газар ашиглах эрх	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч
1.3.газар эзэмших эрх	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, чөлөөт бүсийн нутаг дэвсгэрт чөлөөт бүсийн захирагч
1.4.байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.5.газрын хэвллийн нөхөн сэргээлт хийх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.6.байгаль очрны аудит хийх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.7.усны хайгуул, судалгаа явуулах, цооног өрөмдөх, усны барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнийг барих, тоноглох, ус хэмнэх технологи нэвтрүүлэх, усны шинжилгээ, аудит хийх	байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.8.усны эх үүсвэрийг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.9.аюултай хог хаягдлыг тээвэрлэх,	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн

цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх	захиргааны төв байгууллага
1.10.энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга
1.11.озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмжийн импортлох, худалдах, ашиглах	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.12.химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах, устгах	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.13.зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хавсралтад заасан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийг экспортлох, реэкспортлох, импортлох	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.13.нэн ховор, ховор амьтныг агнах, барих	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.14.нэн ховор амьтныг эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнах, барих	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.15.нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах	Засгийн газар
1.16.ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.17.харь амьтныг нутагшуулах, есгеж үржүүлэх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.18.харь эгэл биетнийг ёсгөвөрлөх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.19.хувиргасан амьд организмыг экспортлох, импортлох, дамжин өнгөрүүлэх, ашиглах	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.20.ховор ургамлыг эм үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.21.амьтны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.22.оин мэргжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
1.23.байгалийн ургамлын	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн

мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	захиргааны төв байгууллага
1.24.усны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	
1.25.ус, цаг уур орчны мэргэжлийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

2. Санхүү, эдийн засаг, гааль, хөрөнгө оруулалтын чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх бөгөөд дараахь этгээд олгоно:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
2.1.аудитын үйл ажиллагаа эрхлэх	Санхүү, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
2.2.татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
2.3.хөрөнгийн үнэлгээ хийх	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
2.4.үнэт цаас үйлдвэрлэх	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
2.5.эд хөрөнгийн хонжворт сугалаа гаргах зөвшөөрөл	Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
2.6.гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх	Гаалийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
2.7.гаалийн баталгаат агуулахын үйл ажиллагаа эрхлэх	гаалийн удирдах төв байгууллага
2.8.гаалийн баталгаат үйлдвэрийн газар ажиллуулах	гаалийн удирдах төв байгууллага
2.9.гаалийн баталгаат барилгын талбай ажиллуулах	гаалийн удирдах төв байгууллага
2.10.гаалийн тусгай бус байгуулах	гаалийн удирдах төв байгууллага
2.11.татваргүй барааны дэлгүүр ажиллуулах	гаалийн удирдах төв байгууллага
2.12.гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газар ажиллуулах	гаалийн удирдах төв байгууллага
2.13.гаалийн түр агуулах ажиллуулах	Гаалийн удирдах төв байгууллага

3. Банк, банк бус санхүү, үнэт цаасны чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх бөгөөд дараахь этгээд олгоно:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
3.1.банк байгуулах	Монголбанк
3.2.мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх	Монголбанк

3.3.зээлийн үйл ажиллагаа эрхлэх	Монголбанк
3.4.төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх	Монголбанк
3.5.өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах үйл ажиллагаа эрхлэх	Монголбанк
3.6.гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах	Монголбанк
3.7.үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах үйл ажиллагаа эрхлэх	Монголбанк
3.8.гадаад төлбөр тооцоо хийх	Монголбанк
3.9.зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхлэх	Монголбанк
3.10.банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтэц өөрчлөгддэх	Монголбанк
3.11.банкнаас хувь нийлүүлсэн хөрөнгөд орох буюу хувьцааны хэмжээ, бүтэц өөрчлөгдсөнөөр шинээр хувьцаа эзэмшигч нэмэгдэх, аливаа этгээд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт орох	Монголбанк
3.12.свитчийн үйл ажиллагаа эрхлэх буюу банк хоорондын картын гүйлгээний боловсруулалт хийх	Монголбанк
3.13.зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх	Монголбанк
3.14.Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаад валют, тооцооны нэгжээр үнэ тогтоох, төлбөр тооцоо гүйцэтгэх	Монголбанк
3.15.төлбөрийн үйлчилгээ үзүүлэх	Монголбанк
3.16.систем ажиллуулах	Монголбанк
3.17.төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх	Монголбанк
3.18.мөнгөн гүйвуулгын үйлчилгээ үзүүлэх	Монголбанк
3.19.цахим мөнгө гаргах	Монголбанк
3.20.мөнгөн хөрөнгийн цахим шилжүүлэг хийх	Монголбанк
3.21.төлбөрийн хэрэгсэл гаргах	Монголбанк

3.22.төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх	Монголбанк
3.23.гэрээт төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх	Монголбанк
3.24.аутсорсингийн үйлчилгээ авах	Монголбанк
3.25.Үнэт зүйл хадгалах үйл ажиллагаа эрхлэх	Монголбанк
3.26.санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх	Монголбанк
3.27.актив удирдлагын үйл ажиллагаа эрхлэх	Монголбанк
3.28.ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.29.урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.30.даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.31.давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.32.үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.33.үнэт цаасны арилжаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.34.үнэт цаасны брокерийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.35.үнэт цаасны андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.36.үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.37.үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.38.үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.39.үнэт цаасны итгэмжлэн удирдах	Санхүүгийн зохицуулах хороо
3.40.кастодианы үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.41.хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.42.хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.43.санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо

3.44.үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.45.үнэт цаасны арилжааны тооцооны үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.46.үнэт цаасны арилжааны төлбөрийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.47.банк бус санхүүгийн байгууллага зээл олгох үйл ажиллагаа эрхлэх;	Санхүүгийн зохицуулах хороо
3.48.банк бус санхүүгийн байгууллага валютын арилжаа хийх	Санхүүгийн зохицуулах хороо
3.49.банк бус санхүүгийн байгууллага төлбөрийн баталгаа гаргах	Санхүүгийн зохицуулах хороо
3.50.банк бус санхүүгийн байгууллага төлбөр тооцоны хэрэгсэл гаргах	Санхүүгийн зохицуулах хороо
3.51.банк бус санхүүгийн байгууллага цахим төлбөр тооцоо, мөнгөн гүйвуулгын үйлчилгээ	Санхүүгийн зохицуулах хороо
3.52.банк бус санхүүгийн байгууллага гадаад валютын арилжаа	Санхүүгийн зохицуулах хороо
3.53.банк бус санхүүгийн байгууллага богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	Санхүүгийн зохицуулах хороо
3.54.банк бус санхүүгийн байгууллага итгэлцлийн үйлчилгээ	Санхүүгийн зохицуулах хороо
3.55.банк бус санхүүгийн байгууллага факторингийн үйлчилгээ	Санхүүгийн зохицуулах хороо
3.56.банк бус санхүүгийн байгууллага хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	Санхүүгийн зохицуулах хороо
3.57.банк бус санхүүгийн байгууллага үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	Санхүүгийн зохицуулах хороо
3.58.хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
3.59.нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх, үнэт цаасыг	Санхүүгийн зохицуулах хороо

анхдагч зах зээл дээр санал болгох, худалдах үйл ажиллагаа эрхлэх	
3.60.хувьцаат компанийн хувьцааг нийтэд санал болгон худалдах	Санхүүгийн зохицуулах хороо

4.Хууль зүйн болон нийтлэг бусад асуудлаар доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх бөгөөд дараахь этгээд олгоно:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
4.1.гадаадын иргэн улсын онц чухал объектод ажиллах	Засгийн газар
4.2.иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг, дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, худалдах	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
4.3.сум импортлох, нийтэд худалдах, үйлдвэрлэх, дахин цэнэглэх	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
4.4.иргэний болон харуул хамгаалалтын зориулалттай галт зэвсэг, сум, дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг худалдах төв нээх, салбар нээх	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
4.5.галт зэвсэг, сум ашиглан спортын сургалтын үйл ажиллагаа эрхлэх	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
4.6.хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх	Цагдаагийн ерөнхий газар
4.8.нотариатын үл ажиллагаа эрхлэх	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
4.9.тамга, тэмдэг үйлдвэрлэх	Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
4.10.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх	Хуульчдын холбоо
4.11.галт зэвсгийн гэрчилгээ	Цагдаагийн төв байгууллага
4.12.оюуны өмчийн итгэмлэгдсэн төлөөллийн үйл ажиллагаа эрхлэх	Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
4.13.гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх	Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
4.14.зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүнийг борлуулах үнийн өөрчлөлт	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар
4.15.давамгай байдалтай хуулийн	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө

этгээд бусад этгээдтэй нэгдэх, нийлэх замаар өөрчлөн байгуулагдах, эсхүл ижил төрлийн бараа бүтээгдэхүүн борлуулдаг өрсөлдөгч компанийн энгийн хувьцааны 20-оос дээш, давуу эрхийн хувьцааны 15-аас дээш хувийг худалдан авах, эсхүл харилцан хамаарал бүхий этгээдтэй нэгдэх, нийлэх	газар
4.16.хэмжих хэрэгслийн үйлдвэрлэл, суурилуулалт, засвар, худалдах ажил, үйлчилгээ эрхлэх	Хэмжил зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

5.Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх бөгөөд дараахь этгээд олгоно:

Тусгай зөвшөөрөл	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
5.1.хот байгуулалтын баримт бичиг боловсруулах	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.2.онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.3.өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.4.дунд зэргийн төвөгшилтэй барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.5.онцгой төвөгшилтэй барилга байгууламжийн барилгын ажил эрхлэх	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.6.өндөр төвөгшилтэй барилга байгууламжийн барилгын ажил эрхлэх	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.7.дунд зэргийн төвөгшилтэй барилга байгууламжийн барилгын ажил эрхлэх	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.8.цахилгаан шат, өргөх кран, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.9.даацын хийц, бүтээц, эдлэхүүн, материал түүний түүхий эд болон	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

шатамхай, химиин хортой, эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх	
5.10.барилгын инженер-геологийн судалгаа хийх	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.11.кадастрын зураг хийх үйл ажиллагаа	Барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
5.12.барилгын эх зураг батлах	Тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга
5.13.хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
5.14.ус олборлох, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
5.15.цэвэр ус дамжуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
5.16.цэвэр ус түгээх шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
5.17.орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
5.18.ус дамжуулах төвийн ашиглалт, засвар, үйлчилгээ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
5.19.бохир усны гаргалгааны шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
5.20.бохир ус цуглуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
10.хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйл ажиллагааны чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг энгийн зөвшөөрөлтэйгээр эрхлэх бөгөөд дараахь этгээд олгоно:

<b>Энгийн зөвшөөрөл</b>	<b>Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд</b>
9.1.гадаадын иргэн, харьялалгүй хүн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх	Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
9.2.олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ эрхлэх	Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага
9.3.хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаа эрхлэх	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний асуудал эрхлэсэн төрийн захиргааны байгууллага
9.4.хөдөлмөрийн биржийн арилжаанд оролцогч брокерийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо

11. Эрүүл мэндийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг зөвшөөрөлтэйгээр эрхлэх бөгөөд дараахь этгээд олгоно:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
11.1.эмчлэх үйл ажиллагаа эрхлэх	эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
11.2.эм барих үйл ажиллагаа эрхлэх	эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
11.3.сувилах үйл ажиллагаа эрхлэх	эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
11.4.эх барих үйл ажиллагаа эрхлэх	эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
11.5.сэргээн засах үйл ажиллагаа эрхлэх	эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
11.6.хүний эмийг Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэглээнд гаргах	Эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
11.7.эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа	Эмийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

13. Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг зөвшөөрөлтэйгээр эрхлэх бөгөөд дараахь этгээд олгоно:

Энгийн зөвшөөрөл	Энгийн зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд
13.1.радио төхөөрөмжийг нийтийн үйлчилгээний бус зориулалтаар ашиглах	Харилцаа холбооны зохицуулах хороо

### НАЙМДУГААР БҮЛЭГ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЯНАХ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ХЯНАЛТ ТАВИХ

#### 8.1 дүгээр зүйл. Зөвшөөрлийг хянах, хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих эрх бүхий этгээд, түүний чиг үүрэг

1. Зөвшөөрөл олгох, бүртгэх эрх бүхий этгээд зөвшөөрлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих, зөвшөөрлийн тухай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагын талаар санал дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ Ерөнхий сайдын дэргэд ажиллана.

2. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 11 гишүүнээс бүрдэх бөгөөд Зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлнэ.

3.Зөвлөлийн гишүүдийг томилох, чөлөөлөх тэдгээрийн ажиллах журмыг Засгийн газар батална.

4.Зөвлөл нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.зөвшөөрөл олгох, бүртгэх эрх бүхий этгээдийг арга зүйн удирдлагаар хангах;

4.2.зөвшөөрөл олгож байгаа байдал, түүний үр нөлөөний талаар хяналт шинжилгээ, үнэлгээг тогтмол хийж, санал, дүгнэлт гаргах;

4.3.Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудлаар санал, дүгнэлт гаргах;

4.4.Эрх бүхий этгээдийн зөвшөөрөл олгож байгаа үйл ажиллагаанд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

4.5.зөвшөөрлийн тухай хууль тогтоомж зөрчсөн териин байгууллага, албан тушаалтны шийдвэр, захиргааны актыг хүчингүй болгуулах саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах.

5.Энэ хуулийн хэрэгжилт, зөвшөөрөл шинээр бий болгох, олгох үйл ажиллагааны талаар санал, зөвлөмж гаргуулахаар шинжээч, мэргэжилтнийг татан оролцуулж болно.

## **8.2 дугаар зүйл. Зөвшөөрлийг олгох болон түүнтэй холбоотой үйл ажиллагаанд гаргасан гомдол, хүсэлт, мэдээллийг хянан үзэх**

1.Зөвлөл дараахь үндэслэлээр зөвшөөрөл олгохтой холбоотой санал, гомдлыг шалгана:

1.1.зөвшөөрөл хүсэгч, зөвшөөрөл эзэмшигчийн гомдолоор;

1.2.зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдийн хүсэлтээр;

1.3.хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэл;

1.4.хуульд заасан бусад үндэслэл.

2.Зөвлөлийн гишүүн ахалсан ажлын хэсэг гомдол, хүсэлт, мэдээллийн дагуу эрх бүхий этгээдийн зөвшөөрөл олгож байгаа үйл ажиллагааг хянан шалгаж, уг үйл ажиллагаа зөвшөөрлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд дарамт, ачаалал үүсгэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргана.

**3.Хяналт шалгалтын ажлын дүнг уг ажиллагааг гүйцэтгэж дууссанаас хойш ажлын 5 өдрийн дотор зөвлөлийн хуралдаанд танилцуулж, энэ хуулийн 8.1 дүгээр зүйлийн 4.4, 4.5 дахь заалтад заасан арга хэмжээг авна.**

**4.Зөвлөлийн хуралдаан, үйлажиллагаатай холбоотой журмыг Засгийн газар тогтооно.**

**5.Зөвлөл нь хяналт шалгалтын үр дүнд үндэслэн олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.**

### **8.3 дугаар зүйл.Зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх**

**1.Зөвлөл зөвшөөрөл, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь энэ хуулийн зорилго, зарчим, нөхцөл, шаардлагад нийцэж байгаа эсэхэд энэ хуулийн 8.4 дүгээр зүйлд заасан үзүүлэлтээр хяналт шинжилгээ, үнэлгээг гурван жил тутам хийнэ.**

**2.Зөвлөл энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний дүнг үндэслэн тухайн зөвшөөрлийг хэвээр үлдээх, эсхүл зөвшөөрлийг нэг ангиллаас нөгөөд шилжүүлэх, эсхүл зөвшөөрлийн жагсаалтаас хасах, өөрчлөх талаар хууль тогтоомжид холбогдох өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах эсэх талаар дүгнэлт гаргана.**

### **8.4 дүгээр зүйл.Шинээр зөвшөөрөл бий болгох зөвшөөрөлийн нөхцөл, шаардлагыг өөрчлөхөд дүгнэлт гаргах**

**1.Зөвшөөрөл бий болгоход тухайн үйл ажиллагааг төрөөс зохицуулах эсэх, зөвшөөрөл нь зохицуулалтын хамгийн зохистой арга хэрэгсэл мөн эсэх, зөвшөөрөл нь нийгэм, эдийн засгийн хувьд үр ашигтай байх эсэхэд судалгаа, шинжилгээ, үнэлгээ хийх зарчмыг баримтлан олон улсын шаардлага, стандартыг харгалзана.**

**2.Зөвлөл нь дараахь шалгуур үзүүлэлтээр дүгнэлт гаргана:**

**2.1.Улсын Их Хуралд өргөн барьж байгаа хуулийн төсөл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зөвшөөрлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжтой нийцэж байгаа байдал, хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хамгаалахад тухайн шинээр бий болгох зөвшөөрөл нь чухал шаардлагатай эсэх, одоо байгаа зөвшөөрөлтэй давхардах, уялдах эсэх;**

**2.2.Зөвшөөрлийн нэр терлийн зайлшгүй хэрэгцээ, бодлогод үндэслэсэн, эрдээлийн түвшин, үнэлгээтэй уялдсан байдал;**

**2.3.Эдийн засаг, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөлөл;**

**2.4. тухайн шинээр бий болгох зөвшөөрөлтэй холбогдуулан улсын төсвөөс болон иргэн, хуулийн этгээд, хэрэглэгчээс гарах зардал.**

**3. Зөвшөөрлийн нэр төрөл шинээр бий болгох хуулийн төслийн талаарх дүгнэлтийг санал, зөвлөмжийн хамт Засгийн газрын хуралдаанд танилцуулж, холбогдох арга хэмжээг авна.**

**8.5 дугаар зүйл. Зөвшөөрөл олгохтой холбогдсон  
маргааныг шийдвэрлэх**

**1. Хүн, хуулийн этгээд зөвшөөрөл олгох болон түүнтэй холбоотой гомдлыг зөвшөөрлийг олгосон эрх бүхий этгээдийн дээд шатны байгууллагад, эсхүл гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагад гаргана.**

**2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан байгууллага байхгүй бол тухайн зөвшөөрөл олгон эрх бүхий этгээдэд гомдол гаргаж болно.**

**8.6 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөх болох**

**1. Энэ хуулийг 2019 оны ... дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.**

**Гарын үсэг**

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
 хот

### АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэгт" гэж, мөн зүйлийн 4.8 дахь хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.3, 6.4-т заасан журмыг" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 4.6 дугаар зүйлд заасан журмыг" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" гэснийг "Зөвшөөрлийн тухай" гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн "тусгай зөвшөөрлийн тухай хууль тогтоомжийн" гэснийг "зөвшөөрлийн тухай хууль тогтоомжийн" гэж тус тус вөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

---

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.6.6-д заасан" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 1.4-т" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАЙГАЛЬ ОРЧНЫ ХАМГААЛАХТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Байгаль орчны хамгаалх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “эрхийн бичгээр” гэснийг “зөвшөөрлөөр” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “буюу эрхийн бичгийн” гэснийг “, зөвшөөрлийн” гэж, 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улсын нутаг дэвсгэрт байдаггүй амьтныг” гэснийг “Харь амьтныг” гэж, 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалтын “лицензи” гэснийг “тусгай зөвшөөрөл” гэж, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын “эрхийн бичгийн” гэснийг “зөвшөөрлийн” гэж, 55 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “эрхийн бичиг” гэснийг “тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Эрхийн бичиг” гэснийг “Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” гэснийг “Зөвшөөрлийн тухай хууль” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.-д заасан” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэгт заасан” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"6.1.12.актив удирдлагын үйл ажиллагаа эрхлэх."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАРААНЫ ТЭМДЭГ, ГАЗАР ЗҮЙН ЗААЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” гэснийг “Зөвшөөрлийн тухай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21 дэх заалтын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.14-т заасан" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 5.1-5.13-т заасан" гэж, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.7.1, 15.7.2, 15.7.4, 15.7.8, 15.7.9, 16.2.4, 16.3.3-д заасны дагуу" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 9.1-9.5, 7.3 дугаар зүйлийн 9.1, 9.2 дахь заалтад заасны дагуу" гэж, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлд" гэж, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1-д заасан" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан" гэж, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1-д зааснаас" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙНТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гаалийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2 дахь хэсэг, 139 дүгээр зүйлийн 139.1 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.1-11.1.4-т зааснаас" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэгт зааснаас" гэж, мөн зүйлийн 70.6, 138.4 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" гэснийг "Зөвшөөрлийн тухай" тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Гаалийн тухай хуулийн 146 дугаар зүйлийн 146.1.5 дахь заалт, 153 дугаар зүйлийн 153.1.5 дахь заалт, 167 дугаар зүйлийн 167.1.4 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.1.Бүх төрлийн шатахууны бөөний худалдааг тусгай зөвшөөрлийн, жижиглэнгийн худалдааг зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.”

**2 дугаар зүйл.** Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтын “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” гэснийг “Зөвшөөрлийн тухай хууль” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “тусгай зөвшөөрөл” гэснийг “тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл” гэж, мөн хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэгт” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.Газрын хэвлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.**

**3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.**

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" гэснийг "Зөвшөөрлийн тухай" гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” гэснийг “Зөвшөөрлийн тухай” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.3, 14.4, 14.5.1, 14.5.3, 14.7 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.2, 15.3, 15.4 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 16.1, 16.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1, 17.2, 17.3, 17.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.2, 18.3.1 дэх заалтын “эрхийн” гэснийг “зөвшөөрлийн” гэж, Дөрөвдүгээр бүлгийн гарчиг, 15 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 15.1, 15.1.1 дэх заалт, 17 дугаар зүйлийн гарчиг, 18 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 18.1, 18.4 дэх хэсгийн “эрх” гэснийг “зөвшөөрөл” гэж, 18 дугаар зүйлийн 18.1.3, 18.3, 18.3.3, 18.4 дэх хэсгийн “эрхийг” гэснийг “зөвшөөрлийг” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зээлийн мэдээллийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай[8] хуулийн 11.1.1, 11.1.2-т зааснаас" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас" гэж, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийг "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд" гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1.1-14.1.5-д зааснаас" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### КОМПАНИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Компанийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“8.4.Хуульд өөрөөр заагаагүй бол компани нь зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу холбогдох эрх бүхий байгууллагын бичгээр олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Малын генетик нөөцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.11.7-д заасан" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 8.9 дэх заалтад заасан" гэж, мөн зүйлийн 9.2 дахь хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.1-11.1.5-д заасан" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэгт заасан" гэж, мөн зүйлийн 9.8, 9.9, 9.10 дахь хэсгийн "лиценз" гэснийг "зөвшөөрөл" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.6.3-т заасны” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэгт заасны” гэж, мөн зүйлийн 8.6 дахь хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” гэснийг “Зөвшөөрлийн тухай” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн наиргуулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “тусгай” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" гэснийг "Зөвшөөрлийн тухай" гэж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11-14 дүгээр зүйл" гэснийг "Зөвшөөрлийн тухай хууль" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НӨХӨРЛӨЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Нөхөрлөлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1, 2 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын “тусгай зөвшөөрөл” гэснийг “зөвшөөрөл” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3 дахь заалтын “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.2, 15.3, 15.4, 15.10.5, 15.10.6 болон 15.10.13-т заасан” гэснийг “Зөвшөөрлийн тухай 7.2 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, мөн зүйлийн 7.6, 7.12, 7.13 дахь заалт, заасан” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Радио долгионы тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “ашиглахад” гэсний дараа “зөвшөөрөл авах бөгөөд” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Радио долгионы тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 13.2, 13.5 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2, 18.2, 18.3, 18.4, 18.5, 18.6, 18.7 дахь хэсэг, Дөрөвдүгээр бүлгийн гарчиг, 19 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 19.1, 19.2, 19.2.3 дахь заалт, 20 дугаар зүйлийн 20.5.2 дахь заалтын “эрхийн бичиг” гэснийг “зөвшөөрөл” гэж, 13 дугаар зүйлийн гарчиг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “Эрхийн бичиг” гэснийг “Зөвшөөрөл” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн гарчийн “эрхийн бичиггүй” гэснийг “зөвшөөрөлгүй” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2.2 дахь заалтын “эрхийн бичгээр” гэснийг “зөвшөөрлөөр” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.2, 17.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 18.1, 18.2, 18.5 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалтын “эрхийн бичгийг” гэснийг “Зөвшөөрлийг” гэж, мөн зүйлийн 13.4 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.2.2, 19.2.4 дэх заалтын “эрхийн бичигт” гэснийг “зөвшөөрөлд” гэж, Гуравдугаар бүлгийн гарчиг, 17 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 17.3, 17.4 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.3, 19.2.3, 19.2.7 дахь заалтын “эрхийн бичгийн” гэснийг “зөвшөөрлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” гэснийг “Зөвшөөрлийн тухай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" гэснийг "Зөвшөөрлийн тухай" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” гэснийг “Зөвшөөрлийн тухай” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төмөр замын тээврийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.5 дахь заалтын “гэрчилгээг түдгэлзүүлэх” гэснийг “олгосон тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх” гэж, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэгт” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС, ТЭСЭЛГЭЭНИЙ ХЭРЭГСЛИЙН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” гэснийг “Зөвшөөрлийн тухай” гэж, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэгт” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.10.4-т заасан эрх бүхий хуулийн этгээд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 7.1-7.3 дахь заалтад заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### УРГАМАЛ ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ургамал хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" гэснийг "Зөвшөөрлийн тухай" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд” гэснийг “Зөвшөөрлийн тухай 5.1 дүгээр зүйлд” гэж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хучин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “10.1.4-10.1.11-д” гэснийг “10.1.4-10.1.10-д” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.11 дэх заалтыг хүчин болсонд тооцсугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Үнэт цаасны зах зээлийн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

“24.2. Энэ хуулийн 24.1.1-24.1.14-т заасан үйл ажиллагааг Хорооноос тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр эрхэлнэ.”

**2 дугаар зүйл.** Үнэт цаасны зах зээлийн хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” гэснийг “Зөвшөөрлийн тухай” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Үнэт цаасны зах зээлийн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.18 дахь заалтыг хүчин болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.** Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалтын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.8.7-д заасан" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 13.1-13.12 дахь заалтад заасан" гэж, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" гэснийг "Зөвшөөрлийн тухай" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИСЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Химиийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” гэснийг “Зөвшөөрлийн тухай хууль” гэж, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуульд” гж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” гэснийг “Зөвшөөрлийн тухай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” гэснийг “Зөвшөөрлийн тухай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХЭМЖЛИЙН НЭГДМЭЛ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн  $10^1$  дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэгт” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Чөлөөт бүсийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” гэснийг “Зөвшөөрлийн тухай” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЦАХИМ ГАРЫН ҮСГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Цахим гарын үсгийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” гэснийг “Зөвшөөрлийн тухай” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.1-11.1.4” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт” гэж, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд” гэж, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.3-т зааснаар” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 15 дахь хэсэгт зааснаар” гэж, 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.2-т заасан журмаар” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан журмаар” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цөмийн энергийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1-д зааснаас" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэгт зааснаас" гэж, мөн зүйлийн 19.17 дахь хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.3-т зааснаас" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 4.6 дугаар зүйлд зааснаас" гэж, мөн зүйлийн 19.20 дахь хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаас" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлд зааснаас" гэж, мөн зүйлийн 19.21 дэх хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд заасан" гэж, мөн зүйлийн 19.25 дахь хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.3-т зааснаас" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалтад зааснаас" гэж, мөн зүйлийн 19.27 дахь хэсгийн "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд" гэснийг "Зөвшөөрлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлд" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ИРГЭНИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 26.8 дахь хэсгийн эхний өгүүлбэрийн “олгосон” гэсний дараа, мөн хэсгийн хоёр дахь өүүлбэрийн “эрх” гэсний дараа “зөвшөөрөл,” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АЖ АХҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ  
ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2001 оны 2 дугаар сарын 01-ний өдөр баталсан Аж ахуйн үйл ажиллагааны тухай хуулийг хүчингүй болсонд тооцусугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Үасгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "-харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал" гэсний дараа "зөвшөөрлийн нэгдсэн бодлого." гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдүсүгэй.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТӨГТООХ нь:

Нэг.Зөвшөөрлийн тухай хуулийг баталсантай холбогдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:

1/Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж болон Улсын тэмдэгтийн тухай хуулийг Зөвшөөрлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуультай нийцүүлэх чиглэлээр хууль хоорондын давхардал, зөрчлийг судалж, холбогдох хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан журмын дагуу боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/ Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл холбоотой харилцааг зохицуулсан Засгийн газрын болон төрийн эхиргааны төв байгууллагын гаргасан шийдвэрийг Зөвшөөрлийн тухай /шинэчилсэн найруулга/ хуультай нийцүүлэх;

3/Зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Монгол Улсын Их Хуралд 2020 оны 1 дүгээр сарын дотор танилцуулах.

Гарын үсэг